



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 03 өдөр

Дугаар А/248

Булган

Татвар төлөгчдийн өдрүүдийг
тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 е, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан “Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, Татварын ерөнхий газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/54 тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Татвар төлөгчдийн өдрүүд-2019” үйл ажиллагааг Булган аймагт 2019 оны 05 дугаар сарын 06-10-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулахыг Татварын хэлтэс /Д.Лхагвасүрэн/-т даалгасугай.
2. Татвар төлөгчдийн дунд зохион байгуулах шатрын тэмцээн, болзолт уралдааны шагналын зардлыг нэгдүгээр, татвар төлөгчдөд зориулсан сургалт, сурталчилгааны зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, шаардагдах 9 000 000 /есөн сая/ төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /Д.Батцогт/-т зөвшөөрсүгэй.
3. “Татвар төлөгчдийн өдрүүд-2019” үйл ажиллагааг сумдад зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг тухайн сумын төсвөөс санхүүжүүлэхийг сумын Засаг дарга нарт даалгасугай.
4. Тус өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлсэн тухай тайланг 5 дугаар сарын 25-ны дотор аймгийн Засаг даргын Тамгын газарт тайлагнахыг Татварын хэлтэс /Д.Лхагвасүрэн/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190268

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дугаар сарын 03-ны өдрийн А/248 тоот
захирамжийн нэгдүгээр хавсралт

"ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДРҮҮД 2019" АРГА ХЭМЖЭЭНИЙ
УРАЛДААН ТЭМЦЭЭНИЙ, ЗАРДЛЫН ДҮН

Д/д	Нэр төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
Болзолт уралдааны шагнал				
1	Шилдэг татвар төлөгчдийн шагнал ААН	21	100,000.0	2,100,000.00
2	Шилдэг татвар төлөгчдийн шагнал Иргэн	30	50,000.00	1,500,000.00
3	Гар зургийн уралдаан /1 байр -40.0□, 2-р байр 35.0□, 3-р байр 30.0□/	4	40000 35000 30000	105,000.00
4	Зохион бичлэгийн уралдаан /1 байр - 40.0□, 2-р байр 35.0□, 3-р байр 30.0□/	4	40000 35000 30000	105,000.00
5	Болзолт уралдаанд оролцсон хүүхэд бүрт урамшуулал талархалын хамт гарын бэлэг	300	5,000.00	1,500,000.00
6	Өргөмжлөл /болзолт/	12	2,500.00	30,000.0
	Дүн			5,340,000.00
Татвар төлөгчдийн дунд зохион байгуулах тэмцээн				
7	Шатар /6-8, 9-12, 13-15, 16-18 насанд хүрэгчид /эр, эм/	11	50000 40000 30000	1,320,000.0
8	Шатар шүүгч цалин			90,000.0
9	Өргөмжлөл /шатар/	33	2,500.00	82,500.0
10	Гар бөмбөгийн бооцоот тэмцээн /насанд хүрэгчдэд, холимог, бооцоо 20.0/ 1-р байр-100.0/бооцоо 40%/ 2-р байр-90.0 /Бооцооны 30%/ 3-р байр- 70.0/бооцооны 20%/	3	100000 90000 70000	260,000.0
11	Гар бөмбөг шүүгч цалин Бооцоо 10%			90,000.0
12	Өргөмжлөл /Гар бөмбөг/	3	2,500.00	7,500.0
13	ЕБС-ын сурагчдын дунд "АХА" Тэмцээн		80000 50000 30000	160,000.0
14	Өргөмжлөл /АХА/	4	2,500.00	10,000.0
15	Ахмадын жилийн хүрээнд ахмадуудын дунд хөгжөөнт тэмцээн уралдаан зохион байгуулах			200,000.0
16	ЕБС-ийн сурагчдад хичээлд идэвхтэй оролцсон хүүхдийн гарын бэлэг			200,000.0
	Дүн			2,420,000.0

Аймгийн Засаг даргын 2019 оны 05
дугаар сарын 03 ны өдрийн 402/8 тоот
захирамжийн хоёрдугаар хавсралт

"ТАТВАР ТӨЛӨГЧДИЙН ӨДРҮҮД 2019" АРГА ХЭМЖЭЭНИЙ
СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ЗАРДЛЫН ДҮН

Сурталчилгааны зардал				
1	Шилдэг татвар төлөгчдийг сурталчилсан хуанли гаргах	400	2,500.00	1,000,000.0
2	Шинэ өнгө төрх бүхий Татвар төлөгчдийн өдрийн АННОС	1	150.00	150,000.0
3	Татвар төлөгчдөд Татварын хууль тогтоомж сурталчилсан баннер самбар /1.8*0,80/	2	45,0	90,000.0
	Дүн			1 240 000